

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМНЫ ХАРЬЯА БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

“Боловсролын чанарын шинэчлэл” төсөл

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД БАГА БОЛОВСРОЛЫГ
ЭХ ХЭЛЭЭРЭЭ ЭЗЭМШИЖ БАЙГАА II-V АНГИЙН СУРАГЧДАД ЗОРИУЛСАН “МОНГОЛ
ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН ЖИШИГ ХӨТӨЛБӨР”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАРЫН АВЛАГА,
ДАСГАЛ АЖЛЫН ДЭВТРИЙН ЭХ БЭЛТГЭХ, ХЭВЛЭН НИЙЛҮҮЛЭХ
ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА**

Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлээр Боловсрол, шинжлэх ухааны яам (БШУЯ)-аас хэрэгжүүлж буй “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд Баян-Өлгий аймгийн ерөнхий боловсролын сургуульд бага боловсролыг эх хэлээрээ эзэмшиж байгаа II-V ангийн сурагчдад зориулсан “Монгол хэлний хичээлийн жишиг хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх гарын авлага, дасгал ажлын дэвтрийн эх бэлтгэх, хэвлэн нийлүүлэх /цаашид бараа гэх/ ажлыг гүйцэтгэх сонирхолтой байгууллагуудыг үнийн саналаа ирүүлэхийг урьж байна.

- Үнийн саналыг зөвхөн төгрөгөөр ирүүлнэ.
- Үнийн саналд эх бэлтгэл, (дизайнер, зураачийн хөлс) хэвлэн нийлүүлэх ажил багтана.
- Үнийн саналын хүчинтэй байх хугацаа санал авснаас хойш 30 хоног байна.
- Үнийн санал ирүүлэхдээ тухайн барааны тоо ширхэг болон нэр төрөл бүрд нэгж үнэ болон нийт үнийг 100 хувь санал болгоно.
- Үнийн хөнгөлөлтийг тусган санал болгож болно.

Захиалагч нь шаардлагад нийцсэн бөгөөд хамгийн сайн үнэлэгдсэн үнийн санал ирүүлсэн нийлүүлэгчтэй гэрээ байгуулна.

Шалгарсан нийлүүлэгч нь гэрээ байгуулснаас хойш 45 хоногт багтаан үнийн саналд тусгасан бүтээгдэхүүнийг Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнд хүлээлгэж өгнө. Үнийн санал авах материалыг цахимаар хүлээн авахгүй. Хугацаа хоцорсон материалыг хүлээн авахаас татгалзана.

Үнийн санал (маягт 1)-ыг барааны техникийн тодорхойлолт (маягт 2), бүрдүүлэх материалын хамт битүүмжилж 2022 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн 16:00 цагаас өмнө доорх хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг 2022 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн 16:30 цагт нийтийн өмнө нээх бөгөөд нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв.

Үнийн саналын нээлтэд оролцогчид буюу тэдгээрийн төлөөлөгч оролцох эрхтэй.

Материал хүлээн авах болон үнийн саналын нээлт хийх хаяг:

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМНЫ ХАРЬЯА
БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө-10А,
Багшийн хөгжлийн ордон III давхарт, 304 тоот өрөө, Утас: 70123046

Дараах нэмэлт материалиудыг хавсралтаар ирүүлнэ.

Үүнд:

- Байгууллагын товч танилцуулга, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- Сүүлийн 2 жилд энэ төрлийн бараа нийлүүлж байсан туршлагатайг нотлох 2-оос доошгүй гэрээний хуулбар;
- Барааг нийлүүлсэний дараа баталгаат хугацаанд гологдлыг арилгах, засвар үйлчилгээ үзүүлэх тухай албан мэдэгдэл.

БАРААНЫ ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ 1.

Гарын авлага, дасгал ажлын дэвтэр тус бүрийн үзүүлэлт

№	Анги	Бүтээгдэхүүний нэр	Хэвлэлийн хуудас	Нүүрний тоо	Зургийн эзлэх хувь	Хэвлэн нийлүүлэх тоо	Санал болгосон НӨАТ тооцоогүй үнэ (төгрөгөөр)	
							Нэгж үнэ	Нийт үнэ
1	II	Дасгал ажлын дэвтэр	8	64	70%	9816		
2		Гарын авлага	12	96		9816		
3	III	Дасгал ажлын дэвтэр	8	64	60%	9816		
4		Гарын авлага	12	96		9816		
5	IV	Дасгал ажлын дэвтэр	10	80	50%	9816		
6		Гарын авлага	15	120		9816		
7	V	Дасгал ажлын дэвтэр	10	80	40%	9816		
8		Гарын авлага	15	120		9816		

Оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

НИЙЛҮҮЛЭГЧИЙН САНАЛ БОЛГОЖ БУЙ БАРААНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ МАЯГТ 2.

Гарын авлага, дасгал ажлын дэвтэрт хамаарах техникийн нийтлэг үзүүлэлт

№	Үзүүлэлт	Техникийн тодорхойлолт	Оролцогчийн санал
1	Хэвлэлийн эх	Хэвлэлийн эх бэлтгэнэ.	
2	Номын хэмжээ	A4 Огтлооны өмнөх хэмжээ: 210 x 297; Огтлооны дараах хэмжээ 203 x 290	
3	Хавтасны цаас	340-380 микроны зузаантай 250 гр-ын шохойтой цаас	
4	Хавтасны өнгө	4+1	
5	Хавтасны бүрэлт	Хавтсыг 12 микроноос доошгүй зузаантай бүрэгч /матт/ -ээр бүрнэ.	
6	Дотор цаас	80%-ийн нягтаршилтай /гэрэл нэвтэрдэггүй/ 80 гр-ын гөлгөр шар цаас	
7	Дотор өнгө	4+4	
8	Хэвлэлтийн дараах ажиллагаа	80-аас дээш нүүр бүхий номын блокыг 16-24 нүүрээр дэвтэрлэж, халуун цавуун бэхэлгээгээр бэхэлнэ. Тоолох, өргөж зөөхөд тохиромжтой байдлаар багцална.	
		80 болон 80 хүртэлх нүүртэй номыг өндөрлөгөөгөөр 2 үдэж халуун цавуугаар бэхэлнэ. Тоолох, өргөж зөөхөд тохиромжтой байдлаар багцална.	
9	Эдэлгээ	2 жил	
10	Стандарт	MNS 5418:2008	

Оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг: